

Эмэгтэй нэр дэвшигчдийг дэмжих хөрөнгө босгоход чиглэсэн улс төрийн намуудын хуульчлагдаагүй арга хэмжээ ба туршлагауд

Янживын Төгөлдөр

*Доктор (Ph.D), дэд профессор
Шинжлэх Ухааны Технологийн Их Сургуулийнм
Нийгмийн ухааны салбар
Улаанбаатар, Монгол Улс
tugul@must.edu.mn*

Хураангуй

Монгол Улс шийдвэр гаргах түвшинд жендерийн тэгш байдлын хангах, тэр дундаа эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлого, хэрэгжилт, хууль эрх зүйн шинэчлэл хийж байгаа ч ахиц дэвшил удаашралтай хэвээр байна. Иймд шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоо, төлөөллийг хангахад нөлөөлөх гол хүчин зүйл болох санхүүжилтийн асуудлыг эмэгтэй нэр дэвшигчдэд чиглэсэн улс төрийн намуудын сайн дурын санаачилга, хөрөнгө босгож байгаа арга замуудыг судлахад чиглүүлсэн болно. Мөн судлагдахууны хүрээнд суурь ойлголтуудыг тодруулахыг хичээлээ.

Түлхүүр үгс: *эмэгтэй нэр дэвшигч, улс төрийн намууд, санхүүжилтийн хуульчлагдаагүй арга хэмжээ, сайн туршлагауд*

Unlegalized activities and practice of political parties to raise funds to support women candidates

Tuguldur Yanjiv

*Doctor (Ph.D), associated professor
Division of Social Science
Mongolian University of Science and Technology
Ulaanbaatar, Mongolia
tugul@must.edu.mn*

Abstract:

Mongolia is making policy, implementation, and legal reforms aimed at ensuring gender equality at the decision-making level, including increasing the participation and representation of women, however progress is still slow. It is still ranked below the Asian and global average in the Global Gender Gap Index. Therefore, the issue of financing, which is the main factor affecting the participation and representation of women at the decision-making level, is directed to the study of the voluntary initiatives of political parties aimed at female candidates and the ways in which

<https://orcid.org/0000-0002-5701-5647>



© The Author(s) 2023

<https://creativecommons.org/licenses/by/4.0/>

Received: 26 August 2023

Accepted: 27 September 2023

funds are raised. Also, the researcher tried to give a clear understanding and terms in the scope of the study.

Keywords: *female candidates, political parties, illegal financing special events and good practices.*

I. Оршил

Улс төрийн шийдвэр гаргах түвшний эмэгтэйчүүдийн оролцоо, төлөөллийн индексээрээ манай улс дэлхийн дунджаас доогуур эрэмбэлэгдсээр байна. Дэлхийн эдийн засгийн форумын жил бүр гаргадаг тайланд Монгол Улс шийдвэр гаргах түвшин буюу улс төрийн эрх мэдлийн индексийн үзүүлэлтээрээ нийт 146 орноос 121-д жагсаж байна. Уг үзүүлэлтийн дэлхийн дундаж нь 22.1 хувь байгаа бөгөөд манайх 17.1 хувьтай доогуур байна.

Түүнчлэн УИХ-ын сүүлийн 2 удаагийн сонгуульд нэр дэвшигчдийн дунд эмэгтэйчүүдийн эзлэх байр суурь, төлөөлөл буурсаар байна. 2012 оны УИХ-ын сонгуулийн нийт нэр дэвшигчдээс эмэгтэйчүүдийн тоо 174 бөгөөд 32 хувьтай байсан бол 2016 онд 129 эмэгтэйчүүд ба 25,9 хувь, 2020 онд 478 ба 21.1 болж буурсан үзүүлэлтэй байна.

Шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоо, төлөөллийг хангахад нөлөөлөх хүчин зүйлс олон байх боловч, эдгээрээс санхүүжилтийн асуудлыг нарийвчлан судалсан, зорилтот судалгаа шинжилгээ цөөн байна. Тиймээс эмэгтэй нэр дэвшигчдэд чиглэсэн улс төрийн намуудын санхүүжилтийн сайн дурын санаачилга, хөрөнгө босгож байгаа дэлхий улс орнуудын туршлага, хэрэгжилтийн арга замуудыг судлах хэрэгцээ шаардлагын дагуу судалгааны зорилгыг дэвшүүллээ.

Эмэгтэй нэр дэвшигчдэд нийтлэг тулгардаг гол бэрхшээлүүдийн нэг нь санхүүжилт босгох явдал. Жил ирэх тусам сонгуулийн өртөг нэмэгдэж, шаардлагатай санхүүжилтийн хэмжээ сонгуулиас сонгуульд өсөж байна. Иймд улс орнуудад эмэгтэйчүүд, залуучууд зэрэг нийгмийн төлөөллийг хангахуйц улс төрийн өрсөлдөөний тэгш боломжийг бий болгох зорилгоор зорилтот нэр дэвшигчийг дэмжсэн санхүүжилтийн шинэ бодлого боловсруулах, хэрэгжилтийг хангахад анхаарах болжээ.

Мөн холбогдох судалгаа шинжилгээг хийх, туршлага хуваалцах, шинэ санаачилга, боломжуудыг бий болгох замаар улс төрийн сайн дурын болон төрийн бодлого, шийдвэрийн дагуу тусгай арга хэмжээнүүд ч идэвхжиж байна. Ялангуяа өмнөд, хойд Америкийн орнуудад эмэгтэйчүүдийг улс төрд дэмжих гол хөшүүрэг болж байгаа хөрөнгө босгох хамтын арга хэмжээнүүдийн талаар судлах, бенчмаркингийн шинжилгээ хийж, сайн туршлагаудаас суралцах нь ардчилсан улс орнуудын хамтын зорилго болж байна.

Гэсэн хэдий ч Ази, Африк, Латин Америкийн орнуудад эмэгтэйчүүд эдийн засгийн янз бүрийн шалтгааны улмаас нэр дэвшигч болохоос татгалздаг болохыг судлаачид тэмдэглэсээр байна (Women's Environment and Development Organization 2007, 4-7). Манай улсын хувьд ч уг шалтгаанаар эмэгтэйчүүд нэр дэвшихээс эргэлзэх, татгалзах үндэслэл болдог нь практикаас тодорхой харагддаг. Учир нь эмэгтэй нэр дэвшигч гэр бүлийн өмч хөрөнгөө сонгуулийн зардалд зарцуулах, зээл хүсэх, өмч хөрөнгөө эрсдэлд оруулах, эрхэлсэн ажлаа болон ээж, эхнэрийн бусад асрах үүргээ

орхих зэрэг нийгэм, эдийн засгийн асуудлууд нь тэднийг сонгуульд оролцохоос татгалзах шалтгаанууд болдог. Иймд улс орнууд эмэгтэйчүүд, жендерийн тэгш байдлыг дэмжсэн санхүүжилтийн талаарх бодлого, хөтөлбөрийг санаачлах, сайн үр дүнг хуваалцаж, нөлөөллийн арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхийг уриалж байна.

II. Судалгааны арга зүй

Судалгааны зорилго нь эмэгтэй нэр дэвшигчийг дэмжсэн хөрөнгө босгож буй улс төрийн намуудын санаачилга, туршлагаудыг судалж, улс төрийн практикт хэрэгжүүлэх боломжийн талаар судлахад чиглэсэн болно.

Судалгааны өгүүллийг бичихдээ нийгмийн шинжлэх ухааны чанарын судалгааны баримт бичгийн шинжилгээ, бенчмаркингийн арга, анализ, сентизийн аргыг ашигласан.

Өгүүллийн хүрээнд эмэгтэй нэр дэвшигчдийг дэмжихэд чиглэсэн санхүүжилтийн талаарх улс орнуудын туршлага, үр дүнг хуваалцах зорилгоор судалгааны бенчмаркингийн аргыг түлхүү ашиглав. Бенчмаркингийн арга нь судлагдахууны талаарх хамгийн сайн туршлагаудыг харьцуулан судлах практик ач холбогдолтой шинжилгээний арга юм. Мөн баримт бичгийн шинжилгээний аргаар улс орнуудын эрх зүйн орчны шинжилгээ хийж, холбогдох эрх зүйн зохицуулалт байгаа эсэхийг тодрууллаа.

Үүнээс гадна сонгуулийн эмэгтэй нэр дэвшигчдийн онцлог, гарааны тэгш байдал, санхүүжилтийн зарчим, хуульчлагдсан болон хуульчлагдаагүй зохицуулалт, нөөц, арга хэмжээнүүд гэсэн суурь ойлголтуудыг судалж, судалгааны цар хүрээг уг судлагдахуунаар хязгаарлах оролдлого хийлээ.

III. Судалгааны үр дүн

1. Эмэгтэй нэр дэвшигчдийг дэмжих хөрөнгө босгох арга хэмжээ ба суурь ойлголтууд.

Цаг хугацааны хувьд 2000 оноос хойш улс орнуудад Жендерийн тэгш байдлыг дэмжсэн санхүүжилтийн бодлого, төлөвлөлт, хэрэгжилт, үнэлгээний талаарх судалгаа, шинжилгээний ажил эрчимжсэн байна. Харин Жендерийн тэгш байдлыг хангахад чиглэсэн төрийн шууд болон шууд бус санхүүжилт, хөрөнгө босгох, намуудын санаачилгын талаарх хууль тогтоомж, хэрэгжилт шинэлэг хэвээр байна.

Эмэгтэй нэр дэвшигчдэд чиглэсэн хөрөнгө босгож буй туршлагаас үзэхэд дараахь үндсэн хоёр арга хэмжээ, санаачилгын хүрээнд судлагдаж байна (ННХ ба АСДҮОУХ 2020, 409). Үүнд:

- 1) **Хуульчилсан арга хэмжээ:** Төрийн санхүүжилт хэлбэрээр улс төрийн нам, эмэгтэй нэр дэвшигчдэд санхүүжилт хуваарилдаг. Үүнд:
 - Жендерийн хувьд төвийг сахисан загвартай, харин практикт Жендерийн үр дагавартай байх,
 - Загвар болон хэрэгцээ талаасаа Жендерт чиглэсэн ба эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог төрийн санхүүжилтээр ил тод дэмжсэн байх.
- 2) **Хуульчлагдаагүй арга хэмжээ:** Энэ нь улс төрийн нам сайн дурын үндсэн

дээр авч хэрэгжүүлдэг үйл ажиллагаанууд багтдаг. Үүнд:

- Сайн дурын, зөвхөн асуудлыг хөндөж буй тухайн намд үйлчлэх улс төрийн арга хэмжээнүүд;
- Эмэгтэй нэр дэвшигчдэд шууд санхүүжилт босгоход нь зориулагдсан иргэний нийгмийн арга хэмжээ, бусад санаачилгууд хамаарна.

Энэ өгүүллийн хүрээнд хуульчлагдаагүй арга хэмжээнүүдийн нэг болох эмэгтэй нэр дэвшигчдэд зориулсан улс төрийн намын сайн дурын санхүүгийн дэмжлэг, хөрөнгө босгож буй санаачилга, туршлагуудыг авч үзсэн. Мөн судлаачийн зүгээс шинжилгээг улс төрийн намаас сонгуульд нэр дэвших гурван үе шаттай холбож, эмэгтэйчүүдэд тулгардаг санхүүжилтийн асуудлыг улс орнуудад хэрэгжиж буй сайн туршлагын хамт судлахыг хичээлээ.

Сонгуульд нэр дэвших нь **нэр дэвшихээр шийдэх, нэр дэвших, сонгуулийн кампанит ажил явуулах** (Women's Environment and Development Organization 2007, 3, 4) гэсэн гурван өөр үе шатаас бүрддэг бөгөөд эмэгтэйчүүдийн хувьд нэр дэвшихэд энэ гуравт нөлөөлөхүйц санхүүжилтийн нөөцийг шаарддаг. Харин эмэгтэйчүүд санхүүгийн нөөц бололцоо хязгаарлагдмал бол сонгуульд ялах магадлал буурч, намууд ч эмэгтэйчүүдийг нэр дэвшүүлэхийг дэмжих нь бага болохыг практикаас харж болно.

Нэмж дурдахад сонгуулийн кампанит ажлын үед ашиглагддаг шууд болон шууд бус санхүүгийн нөөцийн талаарх ойлголтыг дээрх нэр дэвших үе шатуудад ангилан авч үзлээ. Эмэгтэй, эрэгтэй нэр дэвшигчид хоёулаа сонгуулийн кампанит ажилдаа шууд болон шууд бус нөөцийг ашигладаг. Нэр дэвшигчийн кампанит ажилд шууд ба шууд бус нөөцийг ялгах нь чухал гэж үздэг (Women's Environment and Development Organization 2007, 3, 4). (Мөнгөн ба мөнгөн бус гэж бас ойлгож болно)

Шууд нөөц гэдэг нь хувийн хандивлагчид, улс төрийн намуудын хөрөнгө, улсын төсвийн санхүүжилт, татаас, эсвэл нэр дэвшигчийн хувийн нөөцөөс гардаг бэлэн мөнгө гэж тодорхойлж болно.

Шууд бус санхүүгийн нөөцийг бэлэн мөнгөөр бус, улс төрийн үйл ажиллагаа, кампанит ажилд тустай материаллаг эдийн засгийн хувь нэмэр гэж тодорхойлдог. Шууд бус эх үүсвэрийг ихэвчлэн нэр дэвшигчийн нэрийн өмнөөс цалингүй хөдөлмөрөө хандивласан хувь хүмүүс, улс төрийн намын гишүүд, дэмжигчид, сайн дурын байгууллагуудын дэмжлэг, тойргийн дэмжигч нар хийдэг. Эдгээрээс хамгийн түгээмэл арга замууд нь кампанит ажлын үйл ажиллагааг явуулахад шаардлагатай холбооны хэрэгсэл, сайн дурынхан, тэдний дэд бүтэц, оффисын дэмжлэг, танил талын сүлжээ зэрэг материаллаг нөөц байж болно.

Эмэгтэй нэр дэвшигчдийн хувьд санхүүгийн эх үүсвэр нь хязгаарлагдмал байх магадлалтай тул эдийн засгийн янз бүрийн шууд бус эх үүсвэрт найдах нь илүү үр дүнтэй юм. Эмэгтэйчүүдийн улс төрийн карьерын дээрх гурван үе шатуудад шууд болон шууд бус нөөцийг ашиглах нь чухал бөгөөд сонгуульд өрсөлдөх шийдвэрт ихээхэн нөлөөлнө гэж үздэг.

Эхний буюу нэр дэвшихээр шийдэх үе шат: Энэ үед эмэгтэйчүүдэд татвар, хураамж, дэнчин босгох зэрэг санхүүгийн асуудлууд гарч ирдэг. Уг асуудалд

чиглэсэн улс төрийн намуудын дэмжлэгүүдийг авч үзвэл эмэгтэйчүүдийн нэр дэвших үеийн намын дотоод сонгууль болон сонгон шалгаруулалтын үед тулгардаг дэнчин, татвар, хураамжийг багасгах эсвэл бүр чөлөөлсөн туршлагууд байна. Мөн эмэгтэй нэр дэвшигчдэд шууд бус санхүүгийн нөөцөөр дэмжлэг үзүүлэх хандлагууд нэмэгдэх болжээ. Шууд бус нөөцийн дэмжлэгт улс төрд оролцоход шаардагдах хувь хүний хөгжлийн ур чадварууд, хөрөнгө босгох стратеги болон холбоо харилцаагаа ашиглах арга зам, сонгуулийн кампанит ажлын менежмент зэрэгт арга зүйн дэмжлэг үзүүлэх сургалт, хөтөлбөр, арга хэмжээнүүдийг улс төрийн намууд түлхүү хэрэгжүүлж байна.

Уг асуудалд хамаарах улс орнуудын санхүүгийн шууд болон шууд бус дэмжлэгийн талаар дурдвал:

- **Намын хураамж, татвар, дэнчин:** Нэр дэвшин сонгуульд оролцохын өмнө хэд хэдэн хураамж, түүний дотор намын гишүүнчлэлийн татвар, нэр дэвшигчийн бүртгэлийн хураамж төлөх шаардлага байдаг. Намын гишүүнчлэлийн татвар нь улс төрийн намуудын орлогын нийтлэг эх үүсвэр бөгөөд намын үйл ажиллагаа болон намын аппаратыг санхүүжүүлэхэд ашигладаг. Түүнчлэн нэр дэвшихийн тулд намдаа эсвэл Сонгуулийн төв байгууллагад бүртгэлийн хураамжаа нэр дэвшигч өөрөө төлөхийг намууд шаарддаг улс орнууд байна. Эдгээр хураамжийн хэмжээ янз бүр байгаа ч зарим эмэгтэй нэр дэвшигчийн хувьд хэт өндөр байх магадлалтай юм. Эмэгтэйчүүдийг албан тушаалд өрсөлдөх явдлыг дэмжих зорилгоор зарим улс төрийн нам тэдний гишүүнчлэлийн татвар, нэр дэвшигчийн бүртгэлтэй холбоотой хураамжийг сайн дураараа багасган, эсвэл чөлөөлсөн туршлагууд байна. Жишээлбэл, Гана Улсад бараг бүх намууд нь эмэгтэйчүүд нэр дэвшихээр бүртгүүлэхэд төлдөг хураамжийг 50 хувь хөнгөлж өгснийг нэгэн эмэгтэй парламентын гишүүн тэмдэглэжээ (ННХ ба АСДҮОУХ 2020).
- Шууд бус санхүүгийн эх үүсвэрийн хувьд авч үзвэл: Хондурасст депутатаар сонгогдсон Гуильям Гуифарро (Women’s Environment and Development Organization 2007) эмэгтэйчүүд зөвхөн олон нийтийн хүрээнд кампанит ажил бэлтгэх зардлыг тооцдог төдийгүй гэр бүлдээ ч зарцуулах хөрөнгө мөнгө шаардагддаг болохыг хэлжээ. Тэрээр хүүхэд асрах, эцэг эхээ асран халамжлах, гэрийн ажил гэх мэт зардлыг эмэгтэйчүүд кампанит ажлынхаа үе шатуудад бүхэлд нь хариуцах ёстой байдаг бөгөөд үүнийг кампанит ажлын зардал болгож оруулах санаачилгыг эхлүүлсэн. Энэ нь эмэгтэйчүүдэд нэр дэвшихээр шийдэх чухал хөшүүрэг болно гэж үзжээ.
- Суринамын ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигч Моник Эссед-Фернандес /Monique Essed-Fernandes/ хэлэхдээ (Cigane ба Ohman 2014, 17-21): “Нэр дэвшигч буй эмэгтэйчүүд нэг бол ганц бие, хүүхэдгүй, том хүүхэдтэй эсвэл хүүхэд асрах дэмжлэгтэй байдаг. Хүүхэд харах үйлчилгээ гэдэг бол нэр дэвшихээс өмнө эхэлдэг асуудал, учир нь амьдрал дээр хүүхэд асрах асуудалтай хүмүүс энэ тогтолцооноос хасагддаг, эсвэл өөрсдийгөө хасдаг” гэжээ. Иймд сонгуулийн санхүүжилтийн зардалд оруулах заалтыг дэмжихийг уриалсан.
- Мөн ийм ажиглалтыг судлаач Уолш /Walsh/ дэвшүүлж, АНУ-д эмэгтэйчүүд

өөрсдийгөө ялах чадвартай нэр дэвшигч болно гэдгийг итгүүлэх нь нэр дэвшихийн өмнөх үе шатанд чухал юм. Үүний тулд эмэгтэйчүүдээс “та нэр дэвших үү?” гэж асуух хэрэгтэй, учир нь тэдний хувьд сэтгэл зүйн хүч чадлыг нэмэгдүүлэх дасгал ажил болно. Үгүй бол тэд цаашид тулгарах эдийн засаг, соёл, мэдээллийн зэрэг бусад саад тотгорыг даван туулах итгэлгүй болно гэж тэмдэглэжээ (Women’s Environment and Development Organization 2007).

Эхний бөгөөд эмэгтэйчүүдийн нэр дэвшихээс өмнөх үе шатанд тэдний нэр дэвшигч болох итгэл үнэмшлийг бэхжүүлэхэд улс төрийн намын үүрэг, оролцоо чухал байна. Намын зүгээс эмэгтэйчүүдэд чиглэсэн сэтгэл зүйн болоод санхүүгийн хөшүүргээр дэмжих сайн дурын санаачилга, тусгай арга хэмжээнүүдийг тогтвортой хэрэгжүүлэх нь нэр дэвшигчийн хувьд өөртөө итгэлтэй, хүчтэй байх сэдэл, чадварыг нэмэгдүүлэх суурь нөхцөл нь юм. Ийм учраас эмэгтэй нэр дэвшигчдэд тулгардаг эдийн засгийн дарамт, “санхүүгийн саад”-ыг бууруулах арга хэмжээнүүдийг улс төрийн нам, мөн эмэгтэйчүүдийн өөрсдийн санал, шаардлагаар эхэлж, зөв хандлагыг бэхжүүлэх хэрэгцээ байна.

Хоёр дахь буюу эмэгтэйчүүдийн нэр дэвших үе шат: Энэ үед эмэгтэйчүүд нэр дэвших эрхээ авсан байх бөгөөд сонгуулийн сурталчилгааны кампанит ажлаа эхлүүлэх санхүүжилт тулгардаг. Ихэнх эмэгтэй нэр дэвшигчдийн хувьд энэ үе шатанд улс төрийн намын дэмжлэг чухал байхаас гадна Жендерийн тэгш байдлыг дэмжих “зөөлөн хувилбар” (Ohman 2018, 10) гэж нэрлэдэг төрийн санхүүжилтийн дэмжлэг гол үүрэгтэй болно. Иймд улс төрийн намууд Жендерийн тэгш байдлыг дэмжих иргэний боловсролыг дээшлүүлэх, улс төрд оролцох сонирхолтой эмэгтэйчүүдийг урамшуулах, зөвлөх, дэмжих зэрэг хуульчилсан ба хуульчлагдаагүй олон арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж буй туршлагауд нэмэгдэж байна.

Хуульчилсан арга хэмжээ бол төрийн санхүүжилт хэлбэрээр улс төрийн нам, эмэгтэй нэр дэвшигчдэд санхүүжилт хуваарилдаг ойлголт юм. Улс орнуудын туршлагаас үзэхэд Сонгуулийн тухай хууль болон Улс төрийн намуудын тухай хуульд намуудын хүлээн авах төрийн санхүүжилтийн хэмжээ, түүний хуваарилалт нь Жендертэй холбоотой заалтууд, эсвэл төрийн санхүүжилтийн зарим хэсгийг Жендерт чиглэсэн хуулийн зохицуулалтаар холбосон эрх зүйн шинэчлэл хийгдэж байна

Гэхдээ энэ үе шатанд эмэгтэйчүүдийн нэр дэвшихэд тулгардаг санхүүжилтийн хуульчлагдаагүй сайн дурын арга хэмжээнүүдийг авч үзэх учраас хуулийн зохицуулалт, төрийн санхүүжилтийг дурдагдахгүй юм.

Эмэгтэйчүүдийн хувьд нэр дэвших эрхээ аваад сонгуулийн сурталчилгааны зардлаа урьдчилан эрт олж чадвал цаашид сонгогдох эмэгтэйчүүдийн тоог нэмэх стратегийн ач холбогдолтой юм. Сонгуулийн сурталчилгааны зардлыг хоёр ба түүнээс дээш жилийн хугацаанд тогтмол хөрөнгө босгож байхаар төлөвлөж чадвал үр өгөөжтэй гэж үзэж байна. Учир нь тойрог, намын гишүүдийн дунд тэдний нэр хүнд, байр сууриа олж авахад нэр дэвшигчдээс маш их цаг хугацаа, хөрөнгө мөнгө зарцуулж, тасралтгүй ажиллах шаардлага тулгардаг. Тухайлбал, харилцаа холбооны зардал болох утас, шуудан, тээвэр, нүүр тулсан ярилцлага хийх, өөрийгөө таниулах арга хэмжээнд тойргийн иргэдтэй уулзах зардал, олон нийтийн арга хэмжээ, ярилцлагад орох, бусад зардал буюу хувцас, буудал, хоол гэх мэт далд

хэлбэрийн гэр бүлтэй холбоотой олон үйл ажиллагааны зардлууд эмэгтэйчүүдэд нэмэгддэг байна.

Эдийн засгийн эдгээр хэрэгцээг хангахын тулд улс орнуудад эмэгтэй нэр дэвшигчдийг дэмжих зорилгоор нэгдэж, амжилттай санаачилгуудыг хэрэгжүүлсээр иржээ. Тухайлбал, хамгийн анхдагч санаачилга нь EMILY's List мөн WISH List гэх мэт мөнгө босгох механизмыг хэрэгжүүлсэн туршлага онцлон дурдагддаг. Эмэгтэйчүүдэд урьдчилж эрт мөнгө, хандив босгох нь сонгуулийн сурталчилгааны үеэр илүү их мөнгө цуглуулах магадлалыг нэмэгдүүлдэг гэж үздэг. Иймд уг туршлагыг баримтжуулж, хэрэгжүүлэх санаачилгууд улс орнуудад өргөжин тэлж байна. Уг агуулгыг тусад нь дэлгэрүүлэн авч үзсэн тул энд санааг товчлон дурдлаа.

Гурав дахь ба сонгуулийн кампанит ажлын үе шат: Сонгуулийн кампанит ажлын сурталчилгаа нь тухайн улсын сонгуулийн системийн онцлог, улс төрийн санхүүжилтийн бодлого, эрх зүйн зохицуулалт, намын дотоод дүрэм, журам зэргээс хамаараад өөр өөр байдаг. Энэ үе шатанд эмэгтэй нэр дэвшигчдэд чиглэсэн сонгуулийн сурталчилгааны хөнгөлөлт, урамшуулал, хязгаарлалт, хориг зэрэг хуульчилсан арга хэмжээнүүдийг төрийн санхүүжилттэй уялдуулсан зохицуулалт улс орнуудад нийтлэг хэрэгжиж байна.

Малави Улсын нэгэн эмэгтэй парламентын гишүүний тэмдэглэснээр (Cigane and Ohman 2014, 21): Нэр дэвших эрхээ намаасаа авсны дараа нэр дэвшигчид сурталчилгаа явуулахын тулд тухайн сонгуулийн жилдээ хоёр дахь удаагаа санхүүжилт олох шаардлагатай тулгардаг гэжээ. Уг асуудлыг шийдвэрлэхэд заримдаа шууд бус санхүүгийн эх үүсвэрийг ашиглах, кампанит ажилд зарцуулах мөнгө, цаг хугацааны хязгаарыг тогтоох зэрэг сонгуулийн хуулийн хязгаарлалтууд эмэгтэй нэр дэвшигчдийн кампанит ажилд эергээр нөлөөлж байгааг дурджээ. Үүнтэй төстэй өөр жишээг дурдвал:

Зүүн Тиморын 2001 оны сонгуулиар эмэгтэй нэр дэвшигчдэд болон эмэгтэйчүүдийг “ялах” магадлалтай нэр дэвшигчдийн жагсаалтад оруулсан намуудад телевизийн сурталчилгааны нэмэлт цаг гаргаж өгч байсан. Бразилд 2009 онд хийсэн шинэчлэлээр эмэгтэй нэр дэвшигчдэд ашиглуулах зорилгоор улс төрийн намуудад хэвлэл мэдээллийн цагийг 10 хувь нэмэгдүүлж өгдөг болжээ. Хэвлэл мэдээллийн тухай хууль тогтоомжид эрэгтэй, эмэгтэй нэр дэвшигчдэд хэвлэл мэдээлэл ашиглах тэгш боломж олгосон, эсвэл намуудад илүү олон эмэгтэйчүүд (ялалт байгуулах магадлалтай газар нь) нэр дэвшүүлэх сонирхлыг төрүүлсэн заалтууд тусгаж байна.

Афганистанд хэдийгээр хэвлэл мэдээллийн цагийг хэрхэн хуваарилах талаар сонгуулийн тухай хуульдаа заагаагүй боловч 2005 оны сонгуулиар эмэгтэй нэр дэвшигчдийн 76 хувь нь хэвлэл мэдээллийг хөнгөлөлттэй үнээр ашиглах боломжийг олгожээ. Харин нийт эмэгтэй нэр дэвшигчдийн 55 хувь нь л үүнийг ашиглажээ.

Зарим судалгаагаар эмэгтэйчүүд сонгуулийн кампанит ажилд зориулж хөрөнгө босгохдоо эрэгтэйчүүдээс дутахгүй амжилттай байдаг нь нотлогддог бол зарим судалгаанд эмэгтэй нэр дэвшигчид өрсөлдөх чадвартай байхын тулд эрэгтэйчүүдээс хамаагүй их хөрөнгө босгох шаардлага тулгарч, ингэснээр хөрөнгө босгоход зарцуулдаг цаг хугацаа ч нэмэгддэг гэж үзжээ(Sanbonmatsu 2017).

Канад улсад явуулсан судалгаагаар эмэгтэй нэр дэвшигчид эрэгтэйчүүдээсээ 10 хувиар илүү мөнгө зардаг болохыг тооцоолон гаргасан (Sidhu and Meena 2007, 31). Мөн сонгуульд нэр дэвших нь улсын Ерөнхийлөгчөөс илүү хэцүү байдаг тул албан тушаалд ажиллаж байгаа нэр дэвшигчийн олон давуу талуудыг хязгаарлаж, тэгш бус байдлыг авч үзэх хэрэгтэй гэжээ (Women's Environment and Development Organization 2007). АНУ-д хийсэн судалгаагаар сонгогчид эрэгтэй нэр дэвшигчдээс илүү эмэгтэйчүүдэд илүү өндөр шаардлага тавьдаг бөгөөд эмэгтэй нэр дэвшигч сонгуулийн сурталчилгааны үеэр алдаа гаргасан тохиолдолд уучлах чадвар багаатай байдаг (Barbara Lee Family Foundation and Lake Research Partners 2012) гэх зэрэг олон асуудлуудыг нэрлэж болно. Харин үүнийг хязгаарлах, тэгшитгэх боломжуудыг улс орнууд сонгуулийн тухай хуульдаа тусгаж, хязгаарлалтын зохицуулалтыг нийтлэг хийдэг.

Дээрх агуулгаас үзэхэд сонгуулийн кампанит ажлын нийт зардлын дээд хязгаарыг тогтоох, тодорхой төрлийн сурталчилгааг хориглох, төрийн санхүүжилтийн хуваарилалт зэрэг элементүүдээр сонгуулийн өрсөлдөөнийг тэгшитгэхийг оролдож, ялангуяа эмэгтэй нэр дэвшигчдийн сонгуулийн кампанит ажлыг дэмжих шууд ба шууд бус хэлбэрийн арга замууд нэлээд идэвхжиж буй нь харагдаж байна.

2. Улс төрийн намуудын эмэгтэй нэр дэвшигчид чиглэсэн санхүүжилт босгох дотоод механизм арга замууд

Нэр дэвшиж буй эмэгтэйчүүдэд тулгардаг санхүүгийн олон сорилтуудыг хүлээн зөвшөөрсний үндсэн дээр улс төрийн намууд санаачилгаараа эмэгтэй нэр дэвшигчдэд санхүүжилт босгох механизм бий болгож байна. Санхүүжилт босгох механизм нь намын дотоод бүтцэд байх бөгөөд төрийн санхүүжилтээс ялгаатай ойлголт юм. Эмэгтэй нэр дэвшигчдийг дэмжих энэ төрлийн санаачилга нь цөөхөн ч сонгуулийн кампанит ажлыг амжилттай болгоход нөлөөлөхүйц хөрөнгө босгосон үр дүн сайтай туршлага болж байна.

Иймд улс орнуудад хэрэгжиж буй эмэгтэй нэр дэвшигчдэд чиглэсэн төрийн санхүүжилтээс үл хамаарах хөрөнгө босгох зорилготой улс төрийн намуудын дэргэдэх сан, хөтөлбөр, арга хэмжээнүүдийг доор нэгтгэн авч үзлээ. Үүнд:

1. АНУ-ын Ардчилсан Намын “Эмилигийн жагсаалт” (EMILY's LIST)
2. Австрали Улсын Хөдөлмөрийн Намын “Эмилигийн жагсаалт”
3. АНУ-ын Бүгд Найрамдах Намын “Хүслийн жагсаалт” (WISH LIST)
4. Канадын Либерал Намын дэргэдэх “Жюди ЛаМарш сан” (Judy LaMarsh Fund)
5. Ирландын Хөдөлмөрийн Намын эмэгтэйчүүдийн бүлгийн “5-Си” хөтөлбөр (“5-C” program)
6. Гана Улсын “Эмэгтэйчүүдийн сан” (улс төрийн намуудаас сонгуульд оролцох эрмэлзэлтэй эмэгтэйчүүдийг дэмжих зорилготой)
7. Эль-Сальвадор Улсын Фарабундо Мартигийн Үндэсний чөлөөлөх фронт (олон намын институт байгуулж, эмэгтэйчүүдэд сургалт явуулдаг)
8. Камбож Улсын Сам Рэнси Намын сонгуулийн сурталчилгааны дэмжлэг хөтөлбөр
9. Их Британи Улсын Консерватив Намын дэргэдэх “Women2Win”

1. Эмилигийн жагсаалт (EMILY'S LIST). АНУ-ын Ардчилсан Намын “EMILY'S LIST” нь сонгуулийн сурталчилгааны ажлын санхүүжилт босгох тод жишээ юм.

“EMILY'S List” гэдэг нэр нь зуурсан гурилыг өсгөдөг хөрөнгө гэсэн утгатай юм. Улс төрийн өрсөлдөөний эхэн үед их хэмжээний хандив босгох нь дараа үеийн хандивлагчдыг татах гол стратегийг баримтлан хөрөнгө босгодог байгууллага юм. (цаашид EMILY-ийн жагсаалт гэх)

EMILY-ийн жагсаалт нь эмэгтэйчүүдийн кампанит ажилд гарааны мөнгө олгох замаар улс төрийн тэгш бус өрсөлдөөнийг өөрчлөх зорилгоор үйл ажиллагаагаа эхлүүлсэн. EMILY-ийн жагсаалтаар дэмжлэг авсан анхны нэр дэвшигчдийн нэг нь Сенатын гишүүн Барбара Микулски байв. Тэрээр 1986 онд өөрийн кампанит ажлын нийт санхүүжилтийн 20% болох 60,000 ам.долларыг EMILY-ийн жагсаалтаас сонгуулийн сурталчилгааны ажлынхаа хугацааны эхэн үед авчээ. Тэрээр Конгресст хамгийн удаан ажиллаж байгаа, Сенатын хүчирхэг хорооны нэг болох Санхүүгийн хорооны даргаар ажилласан анхны эмэгтэй гишүүн юм. 2011 онд тэрээр хэлэхдээ “EMILY байгаагүй бол, EMILY яг цагаа олж туслаагүй бол бас намайг тохирсон нэг дэвшигч гэдгийг харуулахад хэрэгтэй туслалцаа үзүүлээгүй бол би АНУ-ын Сенатад байхгүй байлаа” гэсэн байна. Эндээс уг байгууллагын ач холбогдол, дэмжлэгийн талаарх нотолгоог харж болно.

EMILY-ийн жагсаалт улс төрийн өрсөлдөөний тэгш бус, зөрүүтэй байдлыг өөрчлөхийн тулд зөвхөн гарааны мөнгө олгох анхны зорилгоосоо хальж, нэр дэвшигч болох ирээдүйтэй эмэгтэйчүүд, сонгуулийн багийнханд зориулсан арга барил суулгах сургалт явуулах янз бүрийн төсөл хөтөлбөр, мөн сонгогчид саналаа өгөх явдлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг авч хэрэгжүүлэх болжээ. Сонгуулийн үйл явцын туршид санхүүжилт босгох явдал EMILY-ийн жагсаалтын хамгийн чухал ажлын нэг хэвээр байгаа бөгөөд сайтар сонгож авсан Ардчилсан намын ирээдүйтэй эмэгтэй нэр дэвшигчдэд зориулж санхүүжилт босгох хэлбэрээр ажилладаг.

1992-2006 онд цуглуулсан хандивын хэмжээгээрээ EMILY-ийн жагсаалт нь хамгийн их хөрөнгө босгосон ба одоо ч тэргүүн эгнээнд байсаар ирсэн. 1985 онд үүсэн байгуулагдсанаасаа хойш 100 гаруй эмэгтэйд Конгрессын сонгуульд ялалт байгуулахад нь дэмжлэг үзүүлсэн бөгөөд орон нутгийн сонгуульд ч олон зуун эмэгтэйд тусалжээ. EMILY-ийн жагсаалт эмэгтэй нэр дэвшигчдийг дэмжихэд нийтдээ 350 гаруй сая ам.доллар босгосон нь тус орны кампанит ажлын хөрөнгө босгох бүлгүүд дотор хамгийн их амжилттай ажилласанд тооцогдож байна. EMILY-ийн жагсаалтын амжилт олон улсын хэмжээнд ч анхаарал татаж нэлээдгүй оронд энэ загвараар мөнгө босгох кампанит ажлууд хийгдэх болжээ. /EMILY-ийн жагсаалт түүний он цагийн товч түүхийг Хавсралт 1-д оруулав./

Ийнхүү 1985 онд байгуулагдсан эмэгтэй нэр дэвшигчдэд чиглэсэн хөрөнгө босгох зорилготой хэсэг бүсгүйчүүдийн санаачилга нь одоо уриа лоозон биш, бодит үр дүн туршлага болж бусад улс орнуудад салбарлан тархаж байна. Тухайлбал, Австралийн EMILY-ийн жагсаалт, Английн Хөдөлмөрийн Намын Эмэгтэйчүүдийн сүлжээ зэрэг байгууллагууд нь эмэгтэй нэр дэвшигчдийг дэмжих

хандив цуглуулан, хуримтлал үүсгэх талаар ижил төстэй загварыг ашиглаж байна.

2. Австралийн EMILY-ийн жагсаалт Австралийн Викториа муж улсын тэргүүн асан Жоан Кирнер АНУ дахь EMILY-ийн жагсаалтын амжилтыг анзаарч, Австралийн Хөдөлмөрийн Нам (ALP)-ын эмэгтэйчүүдийг дэмжин хандив хуримтлуулах зарчимд тулгуурласан ижил төстэй байгууллага байгуулах ажил эхлүүлжээ (ННХ and АСДҮОУХ 2020, 414-416). Тус хөдөлгөөнийг 1996 онд өрнүүлэх үед нам доторх барууны чиг баримжаатай хэсэг нь тухайн хөдөлгөөнийг зүүний үзэл баримтлалын арга зам хэмээн эсэргүүцэн тэмцэж байв. Австралийн EMILY-ийн жагсаалт аажмаар бие даасан байгууллага болж үүсгэн байгуулагдсан бөгөөд гишүүдийн 40 хувь нь Австралийн Хөдөлмөрийн Нам бус хүмүүсээр өргөжсөн. Гэхдээ улс төрийн санхүүжилтийн ил тод байдлын үүднээс Австралийн Хөдөлмөрийн Намын дэргэдэх байгууллага хэмээн үздэг.

3. WISH LIST хөдөлгөөн (ННХ and АСДҮОУХ 2020, 416-419) нь Бүгд Найрамдах Намын ирээдүйтэй гэгдэх эмэгтэй нэр дэвшигчдэд санхүүжилт босгох, дэмжлэг үзүүлэх зорилгоор 1992 онд байгуулагджээ. Бүгд Найрамдах Намын сонгуулийн ажилд санхүүжилт босгох энэхүү бүлэг нь ЭМИЛИ-ийн жагсаалтын нэгэн адил сонгож авсан өрсөлдөгчдөд санхүүгийн туслалцаа үзүүлэх, хөрөнгө мөнгө босгох, сонгуулийн сурталчилгааны менежмент, хэвлэл мэдээллийн арга техник зэрэг чиглэлээр зөвлөгөө, стратегийн дэмжлэг үзүүлэхэд илүү чиглэж ажилладаг.

Үүсэн байгуулагдсанаасаа хойш WISH жагсаалтын хүчин чармайлтаар Бүгд Найрамдах Намын эмэгтэй нэр дэвшигчдэд зориулан 3.5 сая ам.доллар босгож чадсан бөгөөд Сенат дахь тус намын эмэгтэйчүүдийн тоог дөрөв дахин өсгөж, Төлөөлөгчдийн танхим дахь тус намын эмэгтэйчүүдийн тоог хэвээр хадгалахад хувь нэмрээ оруулж чаджээ.

4. Жюди ЛаМарш сан: Канадын Либерал нам эмэгтэй нэр дэвшигчдэд дэмжлэг үзүүлэх мөнгө босгох зарцуулах зорилгоор Жюди ЛаМарш сан байгуулжээ (Judy LaMarsh Fund 2023). Сангийн санхүүжилтийг хэрхэн зарцуулах нь аль эмэгтэй нэр дэвшигчид эн тэргүүнд санхүүжилт өгөх зэрэг асуудлыг тус нам шууд мэдэж шийддэг аж. Дээрх сан Канадын санхүүжилтийн эрх зүйн зохицуулалтын хүрээнд гол төлөв хөрөнгө санхүүжилт босгох арга хэмжээ зохион байгуулан захидал явуулах, интернэт ашиглах замаар санхүүжилтээ босгодог. Энэ арга нь сонгуулийн ажлаа амжилттай явуулахад нь эмэгтэйчүүдэд мөнгөн ба мөнгөн бус хандив өгөхөд чиглэсэн шинэчлэл болсон. Гол санаачилга нь эмэгтэйчүүдийн нуруун дээр байдаг бусдыг халамжлах, хүүхэд асрах зэрэг хариуцлагуудыг сонгуулийн сурталчилгааны үед хослуулах үндэслэлийг гаргаж, шийдвэрлэж чадсан. Тодруулбал, Канадын Либерал намаас нэр дэвшүүлэх үеэр эмэгтэйчүүдэд хүүхэд асрах үйлчилгээ авахад нь 500 хүртэлх канад доллар (\$440) –ын нөхөн олговор олгож, газар зүйн хувьд өргөн удам сонгуулийн тойргоор явахад нь нэмэлт санхүүжилт хуваарилдаг болжээ. Хүүхэд асрах үйлчилгээний төлбөрийг буцаан олгох, эсвэл мөнгөн бус дэмжлэг үзүүлэх зэрэг өөр бусад санаачилгууд ч бий болжээ.

5. Ирландын Хөдөлмөрийн Намын “5-Си” хөтөлбөр (ННХ and АСДҮОУХ 2020): Эмэгтэйчүүдийн нийгэмд эзлэх байр суурь, нэр хүндэд нөлөөлж байгаа (Confidence, Childcare, Cash, Candidate Selection and Culture) өөртөө итгэх итгэл,

хүүхэд асрах, бэлэн мөнгө, нэр дэвшигчийн сонголт ба соёл гэсэн таван зорилтот сорилтуудыг шийдвэрлэх санаачилга дэвшүүлсэн. Тус нам эмэгтэй гишүүддээ сургалт семинар хийх, сонгогч дэмжигчдэд хүрч ажиллах зэрэг арга хэмжээ зохион байгуулж, эмэгтэй нэр дэвшигчдийн өмнөөс санхүүжилт босгодог бөгөөд шинээр элссэн эсвэл анх удаа нэр дэвшиж буй эмэгтэйчүүдийг дэмжихэд онцгойлон анхаардаг.

6. Гана Улсын “Эмэгтэйчүүдийн сан” (ННХ and АСДҮОУХ 2020, 412) тодорхой улс төрийн намуудаас сонгуульд оролцох эрмэлзэлтэй эмэгтэйчүүдийг дэмжих зорилготой Эмэгтэйчүүдийн сан үүсгэн байгуулах амлалт авсан байна. 2011 онд болсон тус улсын намуудын уулзалт дээр хүлээн авсан санхүүжилтийнхээ 10 хувийг улс төрч болох эрмэлзэлтэй эмэгтэйчүүдэд шууд зарцуулах санал гаргасан мэдэгдлийг хэд хэдэн нам хийжээ.

7. Фарабундо Мартигийн Үндэсний чөлөөлөх фронт (ФМҮЧФ) (ННХ and АСДҮОУХ 2020, 415) нам нь Эль Сальвадор Улсын эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих зорилготой Сонгуулийн хороо байгуулсан байна. Тус хороо нь дотоодын болон гадаадын компани, дэмжигч, гишүүдэд хандан санхүүжилт босгох арга хэмжээ зохион байгуулсан. Тухайлбал, сурталчилгааны зардал гаргуулах зорилгоор нэр хүндтэй бизнес эрхлэгчдийн дунд зоог барих, бусад зорилтот бүлгүүдээс хөрөнгө босгох зэрэг нэмэлт арга хэмжээг зохион байгуулдаг. Босгосон санхүүжилтээ бүх эмэгтэй нэр дэвшигчийг хэвлэл мэдээллээр таниулах, тэдний нэр бүхий зурагт хуудас, өмсгөл, намын хөтөлбөрийг хэвлэн орон даяар тараах зэрэгт зарцуулжээ.

8. Камбож Улсын “Сам Рэнси” (ННХ and АСДҮОУХ 2020, 414) нам нь сонгуулийн ажилд шаардлагатай эд зүйлс болох сурталчилгааны үед өмсөх хувцас, тээврийн хэрэгсэл зэргээр эмэгтэй нэр дэвшигчдийг хангадаг. Хувцас, тээврийн хэрэгсэл, сонгуулийн сурталчилгааны материал зэрэг мөнгөн бус эдээр өгөх хандив нь эмэгтэй нэр дэвшигчдэд учирч болох санхүүгийн ачааллыг бууруулна гэж үздэг. Уг байгууллага нь орон нутаг, муж, холбооны түвшинд нэр дэвшигчдээс ур чадварын талаарх хүсэлтийг хүлээн авч, эдгээрийг холбогдох сайн дурын мэргэжилтнүүдтэй холбож өгдөг байна (Spangler 2017).

9. Их Британийн Women2Win (Women2 Win 2023): Women2Win-ийг 2005 онд Кеннингтоны Баронесса Женкин /**Baroness Jenkin of Kennington**/, парламентын гишүүн Рт Хон Тереза Мэй /**Rt Hon Theresa May**/ нар Консерватив намаас илүү олон эмэгтэй нэр дэвшигчид болон тэдний хэрэгцээтэй кампанит ажлыг явуулж, сурталчлах, сургалтаар хангах зорилгоор үүсгэн байгуулжээ.

Women2Win нь парламент болон улс төрд консерватив үзэлтэй эмэгтэйчүүдийн тоог нэмэгдүүлэх зорилготой бөгөөд төрийн албан тушаал, мөн сонгуульд нэр дэвшиж буй эмэгтэйчүүдийг олонд таниулах, тэдэнд заавар, зөвлөгөө өгөх зэрэг үйл ажиллагааг явуулдаг. 2005 онд Консерватив намаас парламентын 17 эмэгтэй гишүүн байсан нь парламентад суудалтай намын дөнгөж 9 хувийг төлөөлдөг байжээ. Одоо 15 жилийн дараа, дөрвөн удаагийн сонгуулийн дараа Консерватив парламентын 87 эмэгтэй гишүүн байгаа бөгөөд энэ нь 20 гаруй хувь байна.

IV. Дүгнэлт

Улс төрийн нам нь нэр дэвшигчдийг шилж сонгох, нэр дэвшүүлэх ажлыг хариуцдаг гол институт юм. Мөн намууд сонгуулийн ажлыг удирдан зохион байгуулах, мөнгө санхүүг хянан зарцуулах хариуцлага үүрдэг учир сонгуулийн өрсөлдөөнд эмэгтэйчүүдийг дэмжин ажиллахад чухал үүрэгтэй. Иймд намуудаас Жендерт чиглэсэн бодлого, хөтөлбөрийг санаачлан хэрэгжүүлж нийгэмд тэгш байдлыг хангахад тууштай улс төрийн манлайллын хэрэгцээ шаардлага үгүйлэгдэж байна.

Ялангуяа эмэгтэй нэр дэвшигчдийн кампанит ажлыг дэмжих төрийн санхүүжилтээс үл хамаарах хөрөнгө босгох сайн дурын санаачилгыг эхлүүлэх, мөн бусад шууд бус нөөцийг бүрдүүлэх, ашиглах зэрэг тусгай арга хэмжээнүүдийг зохион байгуулах хэрэгцээ асар их байна. Үүнээс гадна эмэгтэй нэр дэвшигчдийг дэмжиж хөрөнгө босгож чадсан туршлага, арга замуудаас үзэхэд тэдний өөрсдийнх нь санаачилга, оролцоотойгоор амжилттай үр дүнд хүрч, нийгэм олон нийтэд нөлөөлөхүйц арга хэмжээ болж чадсан нь ажиглагдаж байна.

Ийнхүү судалгааны үр дүнд улс төрийн намуудын дотоод санаачилгаар хэрэгжиж буй хуульчлагдаагүй арга хэмжээнүүдийг судлахад дараахь санал, зөвлөмжүүдийг дэвшүүлж болохоор байна. Дэвшүүлж буй саналыг улс төрийн намд болон хуулийн заалтад гэсэн байдлаар хоёр хэсэгт хувааж бичсэн.

Улс төрийн намуудад зориулсан санал, зөвлөмж:

1. Эмэгтэй нэр дэвшигчдийг сонгуульд нэр дэвшихээс эхлэн кампанит ажил дуусах хүртэлх үндсэн гурван үе шатуудад тулгарч байгаа (**нэр дэвшихээр шийдэх, нэр дэвших, сонгуулийн кампанит ажил явуулах**) санхүүгийн асуудалд тулгуурлан шууд ба шууд нөөцүүдийг бүрдүүлэх, ашиглах арга хэмжээнүүдийг улс төрийн намууд санаачлах. Тодруулбал,
 - Нэр дэвшихээр шийдэх үеийн **сэтгэл зүйн болоод санхүүгийн шууд ба шууд бус дэмжлэг үзүүлэх**. Жишээлбэл, нийгэм олон нийтэд танигдахад нь туслах, чиглүүлэх, нэр дэвшихийг санал болгож, үргэлж тэдэнд боломж байгаа гэдгийг мэдрүүлж, итгэлтэй болоход нь туслах нөлөөллийн ажил зохион байгуулах
 - Улс төрийн намын **дотоод аппарат болон улс төрийн шийдвэр гаргах түвшний албан тушаалд нэр дэвшүүлж, томилон ажиллуулах** гэх мэт
2. Нэр дэвшихээр тодорхой болсон эмэгтэй нэр дэвшигчдэд чиглэсэн эрт буюу урьдчилан хандив босгох ЭМИЛИ–ийн жагсаалт, ХҮСЛИЙН жагсаалт шиг сайн дурын хөдөлгөөн, байгууллагыг намууд санаачлан нийгэмд таниулж, жишиг арга хэмжээ болгох:
 - Намын өөрсдийн санаачилгаар хийх арга хэмжээ
 - Эсвэл намууд нэгдэж хамтын санаачилгаар хийх тусгай арга хэмжээтэй болох,
3. Мөн нэр дэвших эрхээ авсан эмэгтэй нэр дэвшигчдийг намын татвар, хураамж, дэнчин зэрэг зардлуудаас чөлөөлөх эсвэл бууруулах,
4. Нэр дэвшигчийн сонгуулийн кампанит ажилд чиглэсэн дэмжлэгийн хувьд хамтран ажиллах хүсэлтэй сайн дурынхны жагсаалтыг гаргаж, дэмжигч, ухуулагч гэх мэт бүлгүүдэд цалингүйгээр сайн дурын хөдөлмөрөө хандивлагчдыг татах арга хэмжээнүүдийг санаачлан зохион байгуулах,

5. Мөн эмэгтэй нэр дэвшигчдэд чиглэсэн сонгуулийн сурталчилгааны болон хэвлэл мэдээллийн зардалд намаас илүү дэмжлэг үзүүлдэг байх,
6. Нэр дэвшиж буй тойрог нь хол, өргөн уудам нутаг дэвсгэртэй тохиолдол зэрэг онцлогуудыг харгалзан унаа, байр, хоол, харилцаа холбоо болон албан томилолтын бусад зардлуудыг төрийн санхүүжилтийн эсвэл бусад намын нөөц санхүүжилтэд тусгаж зарцуулдаг байх,
7. Дотоод болон гадаадын мөнгө босгож буй шилдэг туршлагуудыг баримтжуулж, эмэгтэй нэр дэвшигчдэд чиглэсэн шууд ба шууд бус нөөцийг бүрдүүлэх, ашиглах үр дүнтэй аргуудыг сургалтаар түгээн дэлгэрүүлэх,

Сонгуулийн тухай хуульд өгөх санал:

8. Улс төрийн намуудын зардалд нэр дэвшигчдийн ялангуяа эмэгтэйчүүдийн кампанит ажлын зардлыг нэмэхэд чиглэсэн өөрчлөлтийг сонгуулийн тухай хуульд тусгах, тухайлбал:

Сонгуулийн тухай хуулийн 50.2.-т *“Төрийн аудитын дээд байгууллага нам, эвсэл болон нэр дэвшигчээс сонгуульд зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоохдоо нутаг дэвсгэрийн хэмжээ, байршил, өрхийн болон сонгогчийн тоо, мөн эмэгтэй нэр дэвшигчийн хүйсийн онцлог болон энэ хуульд заасан бусад шаардлагыг харгалзан Сонгуулийн ерөнхий хороо болон Монгол Улсын Ерөнхий аудитор хамтран батална.* гэж нэмэлт өөрчлөлт оруулах.

- Эмэгтэй нэр дэвшигчийн сонгуулийн кампанит ажлын зардалд хүүхэд асрах, асран халамжлах зардлыг багтаана. гэж тодотгож болно.

Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд өгөх санал:

9. Улс төрийн нам дотооддоо санхүүжилтийн нөөцөө хуваарилахдаа эмэгтэйчүүдийн байгууллага, эмэгтэй нэр дэвшигчдэд чиглэсэн хуваарилалт, зарцуулалт байхыг дэмжсэн бодлогын шинэчлэлийг Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль (цаашид ЖЭТБХТ гэх) дараахь нэмэлт өөрчлөлтийг оруулах,

ЖЭТБХТ хуулийн 8.2 заалтад: *“Бүх шатны сонгуульд нэр дэвшигч эрэгтэй эмэгтэй хүний сонгуулийн сурталчилгаанд зориулан улс төрийн намаас үзүүлэх санхүүгийн дэмжлэг ижил хэмжээтэй байна”* заалт нь Жендерийн эрх тэгш байдлыг хангах заалт гэхээсээ илүү тэгшитгэн хуваарилах зарчмыг баримталсан хүйсийн ялгаатай байдлын онцлогийг харгалзан үзээгүй өнгөц зохицуулалт гэж үзэж байна. Тодруулбал, хүүхэд асрах, асран халамжлах зэрэг жам ёсны үүргийг харгалзах ёстой. Иймд дараахь өөрчлөлтийн саналыг дэвшүүлж байна.

Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 8 дугаар зүйл.	Санал болгож буй нэмэлт өөрчлөлт
8.2. Бүх шатны сонгуульд нэр дэвшигч эрэгтэй эмэгтэй хүний сонгуулийн сурталчилгаанд зориулан улс төрийн намаас үзүүлэх санхүүгийн дэмжлэг ижил хэмжээтэй байна.	Бүх шатны сонгуулийн сурталчилгаанд зориулан улс төрийн намаас үзүүлэх санхүүгийн дэмжлэгийг эмэгтэй нэр дэвшигчийн хүйсийн онцлогийг харгалзан нэмэгдүүлж болно.

Ашигласан материал

- Women's Environment and Development Organization. 2007. *Women Candidates and Campaign Finance*. New York city: Women's Environment and Development Organization
- ННХ, and АСДҮОУХ. 2020. *Улс төрийн намын болон сонгуулийн санхүүжилт*. *Улс төрийн санхүүжилтийн гарын авлага*. ред. Д.Энхтуул, Б.Баттуул, П.Эрдэнэжаргал. Уб.
- Cigane, Lolita, & Magnus Ohman. 2014. Political Finance and Gender Equality. *IFES White Paper*. Washington, DC : International Foundation for Electoral Systems.
- Ohman, Magnus. 2018. *Gender-targeted Public Funding for Political Parties: A comparative analysis*. International IDEA.
- Sanbonmatsu, Kira . 2017. Money and Women Candidates. *Political Parity*. October. Accessed October 13, 2023. politicalparity.org/wp-content/inventory-money.pdf.
- Sidhu, Gretchen Luchsinger, and Ruth Meena. 2007. *Electoral Financing to Advance Women's Political Participation: A Guide for UNDP Support*. New York: United Nations Development Programme.
- Barbara Lee Family Foundation , and Lake Research Partners. 2012. Pitch Perfect: Winning Strategies for Women Candidates. *Barbara Lee Family Foundation*. November 8. <https://www.barbaraleefoundation.org/wp-content/uploads/BLFF-Lake-Pitch-Perfect-Wining-Strategies-for-Women-Candidates-11.08.12.pdf>.
2023. *Judy LaMarsh Fund*. October 13. <https://nwlc-clfn.liberal.ca/judy-lamarsh-fund/>.
- Spangler, Lizzy . 2017. Political Organizations That Help Women Run for Office. *Study Breaks: Magazine*. <https://studybreaks.com/news-politics/women-political-organizations-run-office/>.
2023. *Women2 Win*. <https://www.women2win.com/about>.